УЗДоос 1993 оны #282-р захирамжаар хүчингүй 187/1

# УЛААНБААТАР

## хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны

# ТОГТООЛ

Улаанбаатар хот

1980 оны 6 дугаар сарын 18-ний өдөр

дугаар 161

ПИОНЕР СУРАГЧДЫН ӨДРИЙН ЗУСЛАН БАЙГУУЛАХ ТУХАЙ

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1976 оны 27-р тогтоолыг хэрэгжүүлэн ерөнхий боловсролын сургуулийн өнчин, амьдралын гачигдалтай зарим сурагчдын зуны амралтыг зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаанаас ТОГТООХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын зуны амралтын хугацаанд Сүхбаатарын районы 17, Октябрийн районы 9, Найрамдлын районы 48, Ажилчны районы 7, 60-р сургууль дээр төвлөрүүлэн нэг ээлжинд 35-аас доошгүй хүүхэдтэйгээр өдрийн зуслан байгуулан ажиллуулахыг районуудын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай.

2. Өдрийн зусланд амрах хүүхдийн хоолны зардлыг нийтийн шагналын хөрөнгөнөөс 35600 төгрөг гаргаж санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /н.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

3. Өдрийн зуслангийн ажиллах журмыг боловсруулан өгч мөрдүүлэхийг Ардын боловсролын хэлтэс /н.Бат-Өлзий/-д үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ч.ЖАМБАЛ

Улаанбаатар хотын АДХ-ын
гүйцэтгэх захиргааны 1980
оны 161-р тогтоолын хавсралт.

# ЗУСЛАНД АМРУУЛАХ ХҮҮХДИЙН ТООЦОО

| | I ээлжинд авах хүүхэд | Хэдэн ээлж | Бүгд хэдэн хүүхэд амрах | Хоолны үнэ |
|---|---|---|---|---|
| 1. Сүхбаатарын районы 17-р сургууль | 40 | 2 | 80 | 4480 |
| 2. Октябрийн районы 9-р сургууль | 40 | 3 | 120 | 6720 |
| 3. Найрамдлын районы 48-р сургууль | 40 | 2 | 80 | 4480 |
| 4. Ажилчны районы 60-р сургууль | 40 | 4 | 160 | 8960 |
| 5. Ажилчны районы 7-р сургууль | 40 | 4 | 160 | 8960 |
| БҮГД | 200 | | 600 | 33600 төг |

Хоолны зардлыг 1 хүүхэд өдөрт 4 төгрөгөөр бодоход бүгд 33600 төгрөг.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГАА